**МОНГОЛ УЛСЫН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2017 оны 10 сарын 04 өдөр Дугаар А/381 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Сувилахуйн төвийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрмийг нэгдүгээр, Сувилахуйн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтыг хоёрдугаар, Сувилахуйн төвд илгээх үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар батлалсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/-т, Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-т тус тус даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ А.ЦОГЦЭЦЭГ

081295

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 10 сарын 04 -ны өдрийн
А/381 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

# СУВИЛАХУЙН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ

## Нэг. Ниитлэг зүйлс

1.1 Сувилахуйн төв (цаашид "төв" гэх) нь байнгын асаргаа сувилгаа шаардах иргэнд сувилахуйн мэргэжлийн цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий, өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллага байна.

1.2 Төв нь өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв болон эмнэлгээс илгээсэн үйлчлүүлэгчид сувилахуйн тусламж, үйлчилгээг хэвтүүлэн, амбулаториор, гэрээр, өдрөөр, зөвлөгөө өгөх хэлбэрээр үзүүлнэ.

1.3 Төв нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, "Сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ үзүүлэх төвийн бүтэц, үйл ажиллагаа"-ны стандарт болон холбогдох бусад хууль, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журам, заавар, энэхүү дүрмийг мөрдлөг болгон ажиллана.

1.4 Төв нь сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хууль, эрх зүйн хүрээнд тусгай зөвшөөрөл авсан, хуулийн этгээдийн эрх бүхий, албан ёсны нэр, тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, банкинд харилцах данстай байна.

1.5 Төрийн болон орон нутгийн өмчит төв нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын, өмчийн олон хэлбэрийн бусад төв нь тухайн үйл ажиллагаа явуулж байгаа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад харъяалагдаж, аймаг, нийслэлийн төв болон хүн ам төвлөрсөн суурин газарт өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвтэй хамтарч ажиллах анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага байна.

1.6 Төв нь сувилахуйн тусламж, үйлчилгээг асаргаа, сувилгааны үндсэн зарчимд суурилсан сувилахуйн таван шатлалын дагуу үзүүлж, үзүүлсэн тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас батламжилсан сувилгааны түүх, бусад холбогдох бичиг маягтад бүртгэж, баталгаажуулна.

## Хоёр. Төвийн зорилго

2.1 Байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай иргэдэд үзүүлэх сувилахуйн дагнасан, мэргэшсэн, бие даасан тусламжийг хөгжүүлэхэд оршино.

## Гурав. Төвийн зорилт

3.1 Үйлчлүүлэгчийн хэрэгцээнд үндэслэсэн мэргэжлийн сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээг үзүүлэх,

3.2 эмнэлгийн шаардлагагүй хэвтэлтийг бууруулах,

3.3 анхан шатны тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх,

3.4 үйлчлүүлэгч, түүний гэр бүлийн амьдралын чанарыг сайжруулахад оршино.

## Дөрөв. Төвийн баримтлах зарчим

4.1 Орчин үеийн сувилахуйн шинжлэх ухааныг үндэслэгч Ф.Найтингелийн "Хүрээлэн буй орчны онол"-ын:

- Хүн, түүний үнэт зүйлс, нэр төр, хувийн нууцлалыг хүндэтгэн үзэх зарчим,
- Нийгмийн анги давхарга, баян ядуу, арьс өнгө, шашны итгэл үнэмшлээр ялгаварлан гадуурхах үзлээс ангид тэгш эрхийн зарчим,
- Хүнлэг, энэрэнгүй, ил тод, шударга байх зарчмыг баримтална.

4.2 Асаргаа, сувилгааны үндсэн зарчмыг баримтлана.

- Орчин,
- Хооллолт,
- Хувцаслалт,
- Шинж тэмдгийн асаргаа, сувилгаа,
- Сэтгэл зүй/ өөрийгөө асрах чадварыг хөгжүүлэх зарчим

## Тав. Төвийн үзүүлэх тусламж, үйлчилгээний төрөл

Төв нь сувилахуйн мэргэжлийн тусламж, үйлчилгээг дараах төрлүүдээр, эсвэл аль нэгийг нь төрөлжүүлэн үзүүлэх чиглэлээр тусгай зөвшөөрөл авч, зохион байгуулагдсан өмчийн олон хэлбэрийн байгууллага байна. Үүнд:

5.1 Хэвтүүлэн эмчлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв болон эмнэлгээс илгээсэн байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай үйлчлүүлэгчийг урт хугацаанд хэвтүүлэн эмчлэх, сувилах тусламж, үйлчилгээ,

5.2 Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ. Гэрээр сувилахуйн тусламж, үйлчилгээг авахаар хүсэлт гаргасан үйлчлүүлэгчид холбогдох журмын дагуу үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ,

5.3 Өдрөөр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ. Хүнд, архаг өвчтэй, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй боловч явах чадвартай, ар гэрийнхэн нь асаргаа, сувилгааг гэртээ үзүүлэх боломжтой иргэдийг өдрийн цагаар хүлээн авч сувилахуйн болон сэргээн засах, зөвлөгөө өгөх тусламж, үйлчилгээ,

5.4 Сувилахуйн зөвлөгөө өгөх тусламж, үйлчилгээ. Өвчтэй болон эрүүл хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх сургалт явуулах, өвчин эмгэгтэй үед сэтгэл зүй, арга зүйн дэмжлэг, зөвлөгөө өгөх сувилахуйн тусламж, үйлчилгээ

**<u>Зургаа. Төвийн бүтэц, зохион байгуулалт.</u>**

6.1 Төв нь "Сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ үзүүлэх төвийн бүтэц, үйл ажиллагаа"-ны стандартын дагуу өөрийн үзүүлэх тусламж, үйлчилгээнийхээ төрөлд заасан чиглэлүүдээр үзүүлэх тусламж, үйлчилгээнийхээ багтаамж, төрөлд шаардагдах хүний нөөц, эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, эм, техник хэрэгсэл, зориулалтын байраар хангагдсан байхаар үйл ажиллагааг зохион байгуулна.

6.2 Өмчийн олон хэлбэрт суурилсан төв нь холбогдох хууль тогтоомж, эрх зүйд нийцүүлэн батлагдсан удирдлага, удирдлагын зөвлөлтэй байна.

6.3 Төвийн дарга, үүсгэн байгуулагч нь үйл ажиллагааны чиглэл бүрээр байгуулагдсан тасаг, нэгжийн дарга нарыг оролцуулсан удирдлагын зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг тогтооно.

6.4 Төвийн хамтын удирдлагын байгууллага нь удирдлагын зөвлөл байна.

6.5 Удирдлагын зөвлөл нь төвийн даргад зөвлөх, шийдвэрийн үндэслэлд санал өгөх, төвийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах зорилго бүхий нэгж байна.

6.6 Төв нь үйлчилгээнийхээ хүчин чадал, багтаамжаас хамаарч дэргэдээ чанар, ёс зүйн болон стандартад заасан бусад шаардлагатай үйл ажиллагааны чиглэлээр алба, нэгж, асуудал хариуцсан мэргэжилтнийг томилж, зохион байгуулж ажиллуулна.

6.7 Удирдлагын зөвлөл нь тогтоол, дарга нь тушаал гаргана. Хууль, дүрэмд нийцүүлэн гаргасан эдгээр шийдвэрийн заалт бүрийг төвийн бүх нэгж, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан дагаж мөрдөх үүрэгтэй.

6.8 Төвийн дарга нь сувилахуйн бакалавраас дээш боловсролтой, мэргэжлээрээ 10-аас доошгүй, сувилахуйн удирдлагын түвшинд 5-аас доошгүй жил ажилласан, мэргэжлийн ур чадвартай, хамт олны дунд нэр хүндтэй, багаар ажиллах чадвартай хүмүүсээс сонгон шалгаруулах, эсвэл төвийн үүсгэн байгуулагч байна. Удирдахуйн ухаанаар суралцсан бол давуу тал болно.

6.9 Төвийн дарга нь ил тод, нээлттэй, шударга, хамт олныг манлайлах, багаар ажиллах байдлыг үйл ажиллагааны үндсэн зарчмаа болгож, төвийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

6.10 Төвийн даргын эрх, үүрэг:

- Төвийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, зохион байгуулах, ажлын үр дүнг хариуцах;
- Төвийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн ажиллах дүрэм, журмыг тухайн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлах;
- Төвийн дотоод дүрэм, журам, зааврыг боловсруулан хамт олны хурлаар хэлэлцэн баталж, мөрдөж ажиллана.

- Төвийн үйл ажиллагаа, хөгжлийн төлөв байдлын талаар бодлого, төсөл боловсруулан удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;
- Мэргэжилтнүүд, ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, түүний биелэлтийг дүгнэх, цуцлах;
- Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байрны тодорхойлолтыг хянан батлах;
- Гадаад, дотоод үйл ажиллагаанд төвийг бүрэн хэмжээгээр төлөөлөх;
- Өөрийн үйл ажиллагааны тайланг удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэх;
- Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төвийн орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;
- Төвийн алба, тасаг, нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, үр дүнг удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулах;
- Төвийн санхүү, төсвийг зохистой удирдаж, өр, төлбөр үүсгэхгүй байх;
- Төвийн хөрөнгийн хэвийн үйл ажиллагааг хангах, сайжруулах арга хэмжээг авах /тоног төхөөрөмж, барилга байшин гэх мэт/;
- Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах;

6.11 Төвийн даргыг бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө дараах үндэслэлээр удирдлагын зөвлөлийн хурлын тогтоолоор чөлөөлнө. Үүнд:

- Эрүүл мэндийн болон бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан,
- Гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон,
- Өөр ажилд шилжих болсон,
- Манлайлан удирдан зохион байгуулах ур чадваргүй, багаар ажилладаггүй, ёс зүй, харилцаа хандлагын зөрчил гаргасан нь нотлогдсон, дотоодын хяналт хийж, түүний мөрөөр арга хэмжээ авахуулсан, хамт олноос чөлөөлж өгөх хүсэлт гаргасан,

## Долоо. Төвийн үндсэн үйл ажиллагаа

7.1 Төв нь сувилахуйн дагнасан үйлчилгээтэй төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт болон холбогдох дүрэм, журамд заасан сувилахуйн тусламж, үйлчилгээг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, эмнэлгээс илгээсэн үйлчлүүлэгчид, тусгай зөвшөөрөлд заасан төрлөөр чанартай, хүртээмжтэй үзүүлнэ.

7.2 Төв нь холбогдох хууль, эрх зүйн хүрээнд болон энэхүү үлгэрчилсэн дүрмийг баримтлан өөрийн үйл ажиллагааны өвөрмөц онцлогт нийцүүлэн баталсан дүрэмтэй, жил бүр батлан хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байна.

7.3 Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тулгамдсан асуудлаа үнэлж, ойрын болон хэтийн төлөв, стратегийн зорилго, зорилтыг төрийн бодлогын чиглэлд нийцүүлэн төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, төвийн мэргэжилтнүүд болон бусад мэргэжлийн байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөмж өгөх, сургалт, эрдэм

шинжилгээний ажил зохион байгуулах хамтарч ажиллах зэрэг асуудлыг тусган хэрэгжүүлнэ.

7.4 Төв нь тусламж, үйлчилгээндээ хамгийн сүүлд батлагдсан эрүүл мэндийн технологи, оношилгоо, эмчилгээ, сувилахуйн стандарт, заавар, удирдамж, дүрэм, журмыг хэрэгжүүлж, хяналт тавьж, хөндлөнгийн хяналтын тогтолцоог нэвтрүүлж, ажиллана.

7.5 Хэвтүүлэн эмчлэх үйлчилгээний төрөл бүхий сувилахуйн төв нь үйлчүүлэгч урт хугацаанд хэвтүүлэн эмчлэхэд ээлтэй гадна ба дотоод орчинг бүрдүүлсэн байхад онцгой анхаарч ажиллана.

7.6 Төв нь эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн алдааг бүртгэж, мэдээлэх нээлттэй тогтолцоотой, мэргэжлийн алдаа гаргахаас урьдчилан сэргийлж ажиллана.

7.7 Төв нь эрсдлийн үнэлгээ хийж, эрсдлээс сэргийлэх ажлыг төлөвлөн, зохион байгуулж, шийдвэрлэж ажиллана.

7.8 Гамшиг, онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй ажиллана.

7.9 Төв нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийг мөрдүүлж, ёс зүйн болон харилцаа хандлагын зөрчлөөс сэргийлж ажиллана

7.10 Хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандан судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох зэрэг нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулан, үнэлж, үр дүнг тооцож ажиллана.

7.11 Сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ нь үйлчлүүлэгчийн биеийн байдал болон бие даах чадварт үнэлгээ өгч, түүнд тохирсон асаргаа, сувилгааны арга, ажилбарыг сонгон төлөвлөж, хэрэгжүүлэх, дүгнэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар өөрт нь болон асран хамгаалагчдад зааж сургах, сувилахуйн тусламж, үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлж, сувилгааны түүхэнд бичиж тэмдэглэн, баталгаажуулахад чиглэгдэнэ.

## 8. <u>Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар.</u>

8.1 Тасаг, нэгж, албадын түвшинд болон төвийн хэмжээнд чанарын хөтөлбөр, төлөвлөгөө, баталж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

8.2 Төвийн тусламж, үйлчилгээний чанар нь сувилахуйн мэргэшсэн (үйлчлүүлэгчийн биед үнэлгээ өгөх, оношлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, дүгнэх) тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчид хүргэх, үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдал, сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

8.3 Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарыг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Сувилгааны түүх”-ийн маягтын үнэн зөв, чанартай хөтлөлт, үйлчлүүлэгчийн өгүүлэмжээр үнэлнэ.

8.4 “Сувилгааны түүх”-ийн маягтын хөтлөлт/үнэлгээ, сувилахуйн онош, төлөвлөлт, хэрэгжүүлэлт, дүгнэлт/-ийг тасаг, нэгж, албадын түвшинд тогтмол хэлэлцүүлж, сувилагчдын ур чадварыг тасралтгүй сайжруулан, баталгаажуулж, бүртгэлжүүлнэ.

8.5 Төв нь сувилагч мэргэжилтнүүдийг сувилахуйн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай чагнуур, даралтны аппарат, асаргаа, сувилгааны орчин үеийн багаж, техник хэрэгслээр хангах, тусламж, үйлчилгээнд шинэ технологи, инноваци нэвтрүүлэх, сувилагчдыг дадлагажуулах, ур чадварыг нь тасралтгүй сайжруулахад онцгой анхаарч ажиллана.

## 9. Нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх

9.1 Төв нь нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээг хөгжүүлэхдээ Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан дүрэм, журам, тэргүүлэх чиглэлийг баримтална.

9.2 Сувилахуйн тусламж, үйлчилгээнд нотолгоонд суурилсан чанар сайжруулах тогтолцоог бий болгож, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд судалгааны арга барил эзэмшүүлэх, тасралтгүй сургалт зохион байгуулна.

9.3 Төв нь сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх, тусламж, үйлчилгээнд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх, сувилахуйн арга, аргачлалыг сайжруулах сувилагчдын судалгаа, шинжилгээний ажил эрхлэлтийг байнга сайжруулж ажиллана.

9.4 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зарласан болон, төвд зонхилон үзүүлж буй тусламж, үйлчилгээний чиглэлээр нотолгоо, судалгаа шаардлагатай сэдэв, судалгааны ажлын өвөрмөц чиглэлийг зарлаж, байгууллагын, улс орны, олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурал, чуулганыг зохион байгуулж ажиллана.

9.5 Сувилахуйн тусламж, үйлчилгээг сайжруулах чиглэлээр гадаад, дотоодын мэргэжилтнүүдийн хийсэн судалгааны ажлын үр дүнг судалж, нутагшуулах, нэвтрүүлэх арга хэмжээ авч ажиллана.

9.6 Төвийн сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг орчин үеийн мэдээ, мэдээллээр хангах, сурах бичиг, гарын авлага бүхий цахим болон биет номын сан, танхимтай байна.

## Арав. Төвийн эрх, үүрэг

Төв нь дараах эрхтэй:

10.1 Төв нь ард иргэдийг өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, сувилахуйн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх болон бусад холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах бүтэц, хүний нөөц, материаллаг бааз, төсвийг бүрдүүлж зохих хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу захиран зарцуулах;

10.2 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан анхан шатны маягтыг хөтөлж, тайлан мэдээг хугацаанд нь гаргаж, хүргүүлэх;

10.3 Өөрийн орны болон гадаадын улс орны төрийн болон төрийн бус, олон нийтийн ба хувийн хэвшлийн байгууллага, иргэдтэй сувилахуйн шинжлэх ухааныг хөгжүүлэх асуудлаар хамтран ажиллах;

10.4 Төв нь тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй стандартын дагуу үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх;

10.5 Ажилтныг ажилд авах, чөлөөлөх, амжилт гаргаж үр дүнтэй ажилласан тэргүүний ажилтныг шагнаж урамшуулах, дээд байгууллагаас олгох шагналд тодорхойлох болон хууль тогтоомжийн дагуу хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулах;

10.6 Сувилагч, эмнэлгийн мэргэжилтнийг сургах, тогтвор суурьшилтай ажиллуулах боломж нөхцөлөөр хангах;

10.7 Ажилтны нийгмийн асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлэх;

10.8 Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

Төв нь дараах үүрэгтэй:

10.9 Төв нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, тушаал, дүрэм, заавар, стандартуудыг мөрдөх;

10.10 Төв нь "Сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги"-ийн хэрэгжилтийг хангах, сувилахуйн түгээмэл үйлдэл, эмнэлзүйн стандартыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах;

10.11 Төв нь эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд алсын хараа, хэтийн зорилгоо тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, байгууллагын дотоод журам, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэн ажиллах;

10.12 Төв нь хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаа, сургалт сурталчилгаа зохион байгуулах, үйлчлүүлэгчдийг эрүүл мэндийн болон өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах;

10.13 Төв нь өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, сувилах, эмчлэх арга хэмжээг хэрэгжүүлэн, хяналт, тандалт хийхэд баримтлах журам, аргачлал, сувилгааны стандарт, удирдамж, технологийн зааврыг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

10.14 Төв нь тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа чиглэлээрх ололт амжилт, шинэ арга, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх чиглэлээр гадаад улс, бусад байгууллагатай хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;

10.15 Төв нь санхүү төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан санхүүгийн нөөцийн төлөвлөлтийн бодит болон нотолгоонд тулгуурласан байдлыг хангаж ажиллах;

10.16 Төв нь хууль, тогтоомж, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийн хүрээнд тусламж, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай журам гаргаж, мөрдөх;

10.17 Төв нь өөрийн үйл ажиллагааны онцлогийг харгалзсан эрсдлийн журам боловсруулан, хэрэгжүүлэх;

10.18 Төв нь ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, ажлын байрны нөхцлийг сайжруулах талаар хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэн санаачлагатай ажиллах;

10.19 Төв нь ажиллагсадын мэдлэг ур чадварыг байнга дээшлүүлж эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, сахилга хариуцлагын хэм, хэмжээг мөрдүүлж ажиллах;

10.20 Төв нь сувилахуйн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа сургалтын байгууллагуудтай гэрээний үндсэн дээр сургалт, эрдэм шинжилгээний чиглэлээр хамтран ажиллах;

10.21 Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

**Арван нэг Төвийн санхүүжилт**

11.1 Төвийн санхүүжилт нь улсын болон орон нутгийн төсөв, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн санхүүжилт, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр, хууль эрх зүйн хүрээнд өмчийн олон хэлбэрийн байгууллагын дотоод журмаараа тогтоосон үйлчилгээний төлбөрөөс бүрдэнэ.

11.2 Төвийн санхүүжилтийг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтыг үндэслэн, энэхүү тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай иргэдэд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.2, 9.1.3, 9.1.5, 9.1.9-д заасан тусламж, үйлчилгээг үзүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтийг олгоно.

11.3 Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан, даатгалын байгууллагаас гаргасан сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам, гэрээний загвар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг баримтална.

11.4 Төв нь үйлчлэх хүрээний иргэдийн тоог хагас, бүтэн жилээр гарган, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газраар дамжуулан санхүүжилтийн хэмжээг тогтоолгож, даатгалын байгууллагад хүргүүлнэ.

11.5 Төв нь төсөв, төсвийн гүйцэтгэлийн мэдээг нэг иргэнээр тооцсон зардлаар гаргана.

11.6 Тухайн төвөөр үйлчлүүлсэн хөдөлгөөнт хүн ам, бүртгэлгүй иргэн, түр оршин суугаа иргэд үйлчлүүлсэн тохиолдолд тусламж үйлчилгээний гүйцэтгэлд суурилсан төлбөрийн аргаар бодож олгоно.

11.7 Санхүүгийн тайланг "Нэгтгэсэн санхүүгийн тайлан ба хяналтад байгаа байгууллагын нягтлан бодох бүртгэл" стандартын дагуу гаргаж тайлангийн нэгтгэлд хамруулна.

11.8 Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага нь төлбөртэй сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлсэнийг холбогдох хууль эрхийн хүрээнд тооцоог гаргаж, тайлагнана.

**Арван хоёр Хяналт, шинжилгээ үнэлгээ**

12.1 Төв нь нь бүтэц, үйл ажиллагааны стандарт, дүрэм, хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцно.

12.2 Чанарын, халдварын сэргийлэлт, сувилахуйн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдал болон холбогдох тушаал шийдвэр, албан даалгавар, стандарт, эмнэл зүйн удирдамж, заавар, дүрэм, журмын хэрэгжилтэд дотоод, ба хөндлөнгийн хяналт шинжилгээ үнэлгээ хийж, үр дүнг тооцно.

12.3 Хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнд тулгуурлан мэргэжилтнүүдийг урамшуулах болон илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг төлөвлөнө.

12.4 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, мэдлэг ур чадварт үнэлгээ өгч, урамшуулал, хариуцлагын тогтолцоог нэвтрүүлнэ.

12.5 Үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчдийн эрэлт, хэрэгцээ, санал хүсэлт, гомдлын мөрөөр хяналт хийхдээ дараах шалгуурыг баримтална. Үүнд:

12.5.1 Үйлчлүүлэгч төвтэй тусламж, үйлчилгээ нь:

- Үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн хүлээлт, хийхээр хүсч буй асуудлыг нь тодорхойлж, туслалцаа үзүүлсэн байдал,
- Тусламж, үйлчилгээ нь үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийн хэрэгцээ, хүсэл сонирхолтой нийцэж буй байдал.

*12.5.2* Үр дүнтэй тусламж:

- Үзүүлсэн тусламж, үйлчилгээ нь тавьсан зорилгод хүрсэн байдал,
- Тусламж, үйлчилгээний үр дүнгийн эерэг байдал

*12.5.3* Тэгш, хүртээмжтэй байдал:

- Үйлчлэх хүрээний хүн амын хамрагдалтын байдал,
- Үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн үнэлгээ,
- Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны дүн,

*12.5.4* Нотолгоо, мэдлэгт суурилсан тусламж үйлчилгээ:

- Үйлчлүүлэгчий өөрөө, өөртөө үйлчлэх чадварыг сэргээх, архаг, хүнд өвчний өвдөлт, зовиур, шаналгааг намжаасан байдал

12.6 Хяналт, шинжилгээ үнэлгээ хийсэн ажлын үр дүнгийн тайланг төвийн удирдлага, холбогдох бүтцийн нэгжид хэлэлцүүлж, хамт олон, иргэдэд нээлттэй мэдээлнэ.

Эрүүл мэндийн сайдын
2017 оны ... сарын ... -ны өдрийн
... дугаар тушаалын 2 дугаар хавсралт

## СУВИЛАХУЙН ТӨВД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ

**Нэг. Төвд үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээний жагсаалт**

| № | Тусламж,үйлчилгээний нэр | Эх сурвалж, анхаарах зүйлс | Хэвтүүлэн эмчлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Өдрөөр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Сувилахуйн зөвлөгөө өгөх тусламж, үйлчилгээ |
|---|---|---|---|---|---|---|
| | 1. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ | | | | | |
| 1 | Зонхилон тохиолдож буй өвчин эмгэг, түүний давтамж, урьдчилан сэргийлэх асуудлаар танилцуулга, сэрэмжлүүлэг, зөвлөгөө өгөх | Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг,<br><br>ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана. | + | + | + | + |
| 2 | Өртөмтгий бүлгийн хүн амд эрсдэлт хүчин зүйлүүд түүнээс урьдчилан сэргийлэх арга барил эзэмшүүлэх сургалт, зөвлөмж өгөх | | + | + | + | + |
| 3 | Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, сургалт, сурталчилгааг явуулах, эрүүл амьдралын хэв маягт сургах, дадлагажуулах | | + | + | + | + |
| 4 | Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж, сургалт, сурталчилгаа хийх | | + | + | + | + |

| № | Тусламж,үйлчилгээний нэр | Эх сурвалж, анхаарах зүйлс | Хэвтүүлэн эмчлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Өдрөөр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Сувилахуйн зөвлөгөө өгөх тусламж, үйлчилгээ |
|---|---|---|---|---|---|---|
| 5 | Осол, гэмтэл, бэртлээс сэргийлэх, хүүхэд, настанд аюулгүй орчин бүрдүүлэх арга барилд сургах, зөвлөмж өгөх | | + | + | + | + |
| 6 | Хорт зуршил (архи, тамхи, мансууруулах бодис)-ын хор хөнөөл, урьдчилан сэргийлэх арга, ажиллагаа зохиох | | + | + | + | + |
| 7 | Бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх | | + | + | + | + |
| 8 | Томуу ба томуу төст өвчин, бүх нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлтийн үед гэрийн нөхцөлд хийх урьдчилан сэргийлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэх | | + | + | + | + |
| 9 | Гэр бүлийн гишүүд болон хамт олонд эрүүл мэндийн боловсрол олгох, сургалт, сурталчилгаа, үзүүлэн таниулах, тараах материал түгээх | | | + | + | + |
| 10 | Гэр бүл төлөвлөлтийн сургалт, сурталчилгаа хийх | | | + | + | + |
| 12 | Гамшиг осол, олон нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлт, онцгой байдлын үеийн сувилахуйн тусламж үйлчилгээний бэлэн байдал | | + | + | + | + |
| 2. СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН БАЙГУУЛЛАГЫН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ | | | | | | |
| 1. | Бие бялдрын түвшин тогтоох сорил авах, анхаарал татсан хүүхдийг хяналтад оруулах, зөвлөмжөөр хангах | ХӨЦМ-ийн сургалтын материал, | | + | + | + |
| 2. | Сургуулийн насны хүүхдийн дархлаажуулалт, дархлаажуулалтын | Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх | | + | + | + |

| № | Тусламж,үйлчилгээний нэр | Эх сурвалж, анхаарах зүйлс | Хэвтүүлэн эмчлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Өдрөөр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Сувилахуйн зөвлөгөө өгөх тусламж, үйлчилгээ |
|---|---|---|---|---|---|---|
| | товлолын талаар мэдээлэл өгөх | бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг,<br><br>ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана. | | | | |
| 3. | Хүүхдэд эрүүл ахуйн дадал хэвшүүлэх (гар угаах, шүд угаах, амны хөндийн эрүүл мэнд, орчны эрүүл мэнд) сургалт явуулах | | | + | + | + |
| 4. | Дунд ахлах ангийнханд бэлгийн хөгжлийн боловсрол, БЗДХ-аас сэргийлэх сургалт явуулах | | | + | + | + |
| 5. | Хорт зуршил, мансууруулах бодисын хорт чанарын талаар сургалт явуулах | | | + | + | + |
| 6. | Сургууль цэцэрлэгийн байгууллагад эрүүл мэндэд ээлтэй орчин, нөхцөл бүрдүүлэх цогц зөвлөгөө өгөх | | | + | + | + |
| | **3. НЯРАЙ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ** | | | | | |
| 1. | Нярайн хоол, тэжээлийн талаар зөвлөмж өгөх | ХӨЦМ-ийн сургалтын материал,<br><br>Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг,<br><br>ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана. | + | + | + | + |
| 2. | Зөв хөхүүлэх арга барил заах, зөвлөгөө өгөх | | + | + | + | + |
| 3. | Нярайн ерөнхий асаргаа, эрүүл бойжуулах зөвлөмж өгөх (орчны чийгшил, агааржуулалт, дулаан, арьс арчлах, хувцаслах,) | | + | + | + | + |
| 4. | БЦЖ вакцины сорвижилт, түүнийг үнэлэх зөвлөгөөг гэр бүлийн гишүүдэд өгөх | | + | + | + | + |
| 5. | Нярайд хүчилтөрөгч өгөх, амьсгалын замыг чөлөөлж, цэр соруулах | | + | + | | |
| 6. | Нярайн рефлексийг үзэж, үнэлэх | | + | + | | |
| 7. | Нярайг жигнэх, урт өндрийг хэмжих | | + | + | + | + |
| 8. | Түнхний үений мултралын эрсдэлтэй | | + | + | + | + |

| № | Тусламж,үйлчилгээний нэр | Эх сурвалж, анхаарах зүйлс | Хэвтүүлэн эмчлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Өдрөөр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Сувилахуйн зөвлөгөө өгөх тусламж, үйлчилгээ |
|---|---|---|---|---|---|---|
| | нярайд өвөрмөц сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэх | | | | | |
| 9. | "0-2" хүртэлх насны хүүхдийг багцын жингээр жинлэх | | + | + | + | + |
| 10. | Шинэ төрсөн нярайг амлуулах | | + | + | + | + |
| 11. | Бага жинтэй нярайг "имж-эх" аргаар дулаацуулах | | + | + | + | + |
| 12. | Нярай хүүхдийг усанд оруулах | MNS 4621:2008 | + | + | + | + |
| 13. | Нүд цэвэрлэх, нүдэнд эм дусаах | | + | + | + | + |
| 14. | Нярай хүүхдийн амны хөндий цэвэрлэх | | + | + | + | + |
| 15. | Нярай хүүхдийн хамар цэвэрлэх, хамарт эм дусаах | | + | + | + | + |
| 16. | Нярай хүүхдэд эм уулгах | | + | + | + | + |
| 17. | Нярай хүүхдийн хүйг цэвэрлэх | | + | + | + | + |
| 18. | Арьсны тууралттай нярай хүүхдийн асаргаа, сувилгаа | | + | + | + | + |
| 19. | Нярай хүүхдэд гич наах | | + | + | | |
| 20. | Нярай хүүхдийн цээжинд доргиох ба тогших иллэг хийх | | + | + | + | + |
| 21. | Нярай хүүхдийн захын хураагуур судсанд уян зүү тавих | MNS 4621:2008 /эмчийн заалтаар/ | + | + | | |
| 22. | Нярай хүүхдийн шээсийг шинжилгээнд авахад бэлтгэх, шинжилгээнд авах | | + | + | | |
| 23. | Нярай хүүхдийн шээсийг нян судлалын шинжилгээнд авахад бэлтгэх, шинжилгээнд авах | | + | + | | |
| 24. | Нярай хүүхдийн баасыг нян судлалын шинжилгээнд авахад бэлтгэх, шинжилгээнд авах | | + | + | | |

| № | Тусламж,үйлчилгээний нэр | Эх сурвалж, анхаарах зүйлс | Хэвтүүлэн эмчлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Өдрөөр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Сувилахуйн зөвлөгөө өгөх тусламж, үйлчилгээ |
|---|---|---|---|---|---|---|
| 4. ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ | | | | | | |
| 1. | Хүүхдийн урт буюу өндрийг хэмжих | ХӨЦМ-ийн сургалтын материал<br><br>Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг,<br><br>ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана. | + | + | + | + |
| 2. | Хүүхдэд халуун, хүйтэн жин, бигнүүр тавих | | + | + | | |
| 3. | Захын хураагуур судсанд уян зүү тавих, заавар өгөх | | + | + | | |
| 4. | Шингэн алдалтын үеийн асаргаа, сувилгаа, шингэн сэлбэх, давсны уусмал бэлдэж уулгахыг заах | | + | + | + | |
| 5. | Эцэг, эх, гэр бүлийн гишүүдэд хүүхдийн эрүүл мэндэд хүрээлэн буй орчны нөлөөний талаар зөвлөмж, сургалт, сурталчилгаа хийх | | + | + | + | + |
| 6. | Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдэд асаргаа, сувилгаа, дасгал, хөдөлгөөн засал хийх, эцэг эх асран хамгаалагчид зөвлөмж, сургалт хийх | | + | + | + | + |
| 7. | Бие, физиологийн өсөлтийн саатaлтай хүүхдэд дасгал, хөдөлгөөн, асаргаа, сувилгаа хийх, эцэг эх асран хамгаалагчид зөвлөмж, сургалт хийх зөвлөмж, сургалт хийх | | + | + | + | + |
| 8. | Хүүхдийн хоол тэжээл, хэмжээ, тэжээллэг чанар, хооллолтын талаар хийх, эцэг эх асран хамгаалагчид зөвлөмж, сургалт хийх | | + | + | + | + |
| 9. | Хүүхдийн өдрийн дэглэм, цаг хуваарилалтын талаар эцэг эх асран хамгаалагчид зөвлөмж, сургалт хийх | | + | + | + | + |
| 10. | Хүүхдийн гэрийн асаргааны зарчмуудыг эцэг эхэд биечлэн үзүүлж сургах | | + | + | + | + |

| № | Тусламж,үйлчилгээний нэр | Эх сурвалж, анхаарах зүйлс | Хэвтүүлэн эмчлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Өдрөөр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Сувилахуйн зөвлөгөө өгөх тусламж, үйлчилгээ |
|---|---|---|---|---|---|---|
| 11. | Амьсгалын замын өвчтэй хүүхдэд сувилахуйн тусламж үзүүлэх заавар өгөх | Зонхилон тохиолдох эмгэгийн үед үзүүлэх сувилахуйн тусламжийн удирдамж /НЭМГ, 2009/ Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг | + | + | + | + |
| 12. | Суулгалттай хүүхдийг үнэлж, шингэн алдалтгүй суулгалтыг гэрээр сувилах | | + | + | + | + |
| 13. | Сульдаатай хүүхдийг сувилах | | + | + | + | + |
| 14. | Тураалтай хүүхдийг сувилах | | + | + | + | + |
| 15. | Шүүдэст эмзэгшилтэй хүүхдэд сувилахуйн тусламж үзүүлэх | | + | + | + | + |
| 16. | Хэрлэг өвчтэй хүүхдэд сувилахуйн тусламж үзүүлэх | | + | + | + | + |
| | **5. ЖИРЭМСЭН ЭМЭГТЭЙ, ТӨРСӨН ЭХ, НЯРАЙД ҮЗҮҮЛЭХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ** | | | | | |
| 1. | Жирэмсэн эмэгтэйн биеийн байдлыг үнэлэх, сувилахуйн тусламж үзүүлэх | Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг, Зонхилон тохиолдох эмгэгийн үед үзүүлэх сувилахуйн тусламжийн удирдамж /НЭМГ, 2009/, ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана. | + | + | + | + |
| 2. | Эрүүл жирэмсэн эмэгтэйг хянах, төрөлтөд бэлтгэх, урьдчилан сэргийлэх дасгал, хөдөлгөөн засал, сэтгэл засал, хоол засал, гэр бүлийн гишүүдэд сургалт зохиох | | + | + | + | + |
| 3. | Бөөрний эмгэгтэй жирэмсэн эмэгтэй, төрсөн эхэд сувилахуйн тусламж үзүүлэх | | + | + | | |
| 4. | Элэгний үрэвсэлтэй жирэмсэн эмэгтэй, төрсөн эхэд сувилахуйн тусламж үзүүлэх | | + | + | | |
| 5. | Гуурсан хоолойн үрэвсэлтэй жирэмсэн эмэгтэй, төрсөн эхэд сувилахуйн тусламж үзүүлэх | | + | + | | |
| 6. | Зүрх судасны эмгэгтэй жирэмсэн эмэгтэй, төрсөн эхэд сувилахуйн тусламж үзүүлэх | | + | + | + | + |
| 7. | Төрсний дараа зонхилон тохиолдох хүндрэлүүдийн үед эхэд сувилахуйн | | + | + | + | + |

| № | Тусламж,үйлчилгээний нэр | Эх сурвалж, анхаарах зүйлс | Хэвтүүлэн эмчлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Өдрөөр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Сувилахуйн зөвлөгөө өгөх тусламж, үйлчилгээ |
|---|---|---|---|---|---|---|
| | тусламж үзүүлэх | | | | | |
| 8. | Сүрьеэ өвчтэй жирэмсэн эмэгтэй, төрсөн эхэд сувилахуйн тусламж үзүүлэх | | + | + | + | |
| 9. | Дотоод шүүрлийн эмгэгтэй жирэмсэн эмэгтэй, төрсөн эхэд сувилахуйн тусламж үзүүлэх | | + | + | + | + |
| 10. | Төв мэдрэлийн системийн эмгэгтэй жирэмсэн эмэгтэй, төрсөн эхэд сувилахуйн тусламж үзүүлэх | | + | + | + | |
| 11. | Нефрозын хам шинжтэй жирэмсэн эмэгтэй, төрсөн эхэд сувилахуйн тусламж үзүүлэх | | + | + | + | + |
| 12. | Хүндрэлтэй жирэмсэн эмэгтэйн хооллолт, жирэмсний онцлог үеүдэд хийгдэх дасгал, хөдөлгөөн, гэр бүлийн гишүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохиох | | + | + | + | + |
| | **6. НАСТАНД ҮЗҮҮЛЭХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ** | | | | | |
| 1 | Настанд сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэх | Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг, ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана. | + | + | + | + |
| 2 | Настанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээр үзүүлэх олон мэргэжлийн багийн үйл ажиллагаа явуулах | | | + | | |
| | **7. ШҮДНИЙ ӨВЧНИЙ ҮЕИЙН СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ** | | | | | |
| 1 | Амны хөндийн салстын өвчний үед | Зонхилон тохиолдох | + | + | + | + |

| № | Тусламж,үйлчилгээний нэр | Эх сурвалж, анхаарах зүйлс | Хэвтүүлэн эмчлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Өдрөөр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Сувилахуйн зөвлөгөө өгөх тусламж, үйлчилгээ |
|---|---|---|---|---|---|---|
| | сувилахуйн тусламж үзүүлэх, сургалт, зөвлөгөө | эмгэгийн үед үзүүлэх сувилахуйн тусламжийн удирдамж /НЭМГ, 2009/ | | | | |
| 2 | Шүдний тойрон эдийн үрэвслийн үед сувилахуйн тусламж үзүүлэх, сургалт, зөвлөгөө | | + | + | + | + |
| 3 | Шүдний цоорлын үед сувилахуйн тусламж үзүүлэх, сургалт, зөвлөгөө | | + | + | | + |
| 4 | Шүдний бусад эмгэгийн үед үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ, сургалт, зөвлөгөө | | + | + | + | + |
| | 8. ЧИХ, ХАМАР ХООЛОЙН ӨВЧНИЙ ҮЕИЙН СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ | | | | | |
| 1. | Чихэнд эм дусаах | MNS 4621:2008 | + | + | | |
| 2. | Чихэнд бигнүүр тавих | | + | + | | |
| 3. | Чих цэвэрлэх | | + | + | | |
| 4. | Чихний хатсан хулхийг цэвэрлэх ба гадны биетийг авах | | + | + | | |
| 5. | Хамарт эм дусаах | | + | + | + | |
| 6. | Хамрын хөндийг угаах | | + | + | | |
| 7. | Хамарт нунтаг эм цацах | | + | + | + | |
| 8. | Хамарт шавшлага хийх | | + | + | + | |
| 9. | Хамарт өмнөд чихээс тавих | | + | + | + | |
| 10. | Хамрын арын чихээс хийх | | + | + | + | |
| 11. | Хоолойд бүлээсгэх боолт хийх, бигнүүр тавих | | + | | + | |
| 12. | Хоолой зайлах | | + | + | + | |
| 13. | Хоолойд эм түрхэх | | + | + | + | |
| 14. | Хоолой утах | | + | + | + | |
| 15. | Хоолойд эм цацах | | + | + | + | |

| № | Тусламж,үйлчилгээний нэр | Эх сурвалж, анхаарах зүйлс | Хэвтүүлэн эмчлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Өдрөөр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Сувилахуйн зөвлөгөө өгөх тусламж, үйлчилгээ |
|---|---|---|---|---|---|---|
| 9. НҮДНИЙ ЭМГЭГИЙН ҮЕД ҮЗҮҮЛЭХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ | | | | | | |
| 1. | Нүдэнд эм дусаах ба нүд угаах | MNS 4621:2008 | + | + | + | |
| 2. | Нүдэнд ганц ба хос боолт хийх | | + | + | + | |
| 3. | Хараагы чадал шалгах | | + | + | + | |
| 4. | Өнгө таних чадварыг шинжлэх | | + | + | + | |
| 5. | Нүдний хараа тогтоох, сэргээх дасгал, хөдөлгөөн заах сургалт, зөвлөгөө | | + | + | + | + |
| 10. СЭТГЭЦИЙН ЭМГЭГИЙН ҮЕИЙН СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ | | | | | | |
| 1 | Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн үеийн сувилахуйн тусламж, үйлчилгээг үзүүлэх, сургалт, зөвлөгөө | Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг, ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана. | + | + | + | + |
| 11. ЕРӨНХИЙ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАРДАН ҮЙЛДЭЛ | | | | | | |
| 1. | Амьсгал тоолох | MNS 4621:2008 | + | + | + | |
| 2. | Биеийн халуун хэмжих | | + | + | + | |
| 3. | Судасны цохилт тоолох | | + | + | + | |
| 4. | Артерийн даралт үзэх | | + | + | + | |
| 5. | Биеийн өндөр, жин үзэх | | + | + | + | |
| 6. | Бумба тавих | | + | + | + | |
| 7. | Гич наах | | + | + | + | |
| 8. | Халуун хүйтэн жин, бигнүүр тавих | | + | + | + | |

| № | Тусламж,үйлчилгээний нэр | Эх сурвалж, анхаарах зүйлс | Хэвтүүлэн эмчлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Өдрөөр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Сувилахуйн зөвлөгөө өгөх тусламж, үйлчилгээ |
|---|---|---|---|---|---|---|
| 9. | Цэвэрлэх бургуй тавих | | + | + | + | |
| 10. | Тэжээлийн бургуй тавих | | + | + | + | |
| 11. | Бичил бургуй тавих | | + | + | + | |
| 12. | Хий гаргах гуурс тавих | | + | + | + | |
| 13. | Утлага хийх | | + | + | + | |
| 14. | Трахеостомийг арчлах | | + | + | + | |
| 15. | Цэр, салс соруулах | | + | + | + | |
| 12. ЭРХТЭН СИСТЕМИЙН ӨӨРЧЛӨЛТТЭЙ НАСАНД ХҮРЭГЧДЭД ГЭРЭЭР ҮЗҮҮЛЭХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ | | | | | | |
| 1. | Амьсгалын замын өвчтэй хүнд сувилахуйн тусламж үзүүлэх, сургалт, зөвлөгөө | Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг, Зонхилон тохиолдох эмгэгийн үед үзүүлэх сувилахуйн тусламжийн удирдамж /НЭМГ, 2009/, ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана | + | + | + | + |
| 2. | Зүрх судасны өвчтэй хүнд сувилахуйн тусламж үзүүлэх, сургалт, зөвлөгөө | | + | + | + | + |
| 3. | Бөөр шээсний замын өвчтэй хүнд сувилахуйн тусламж үзүүлэх, сургалт, зөвлөгөө | | + | + | + | + |
| 4. | Элэгний архаг үрэвсэлтэй өвчтөнд сувилахуйн тусламж үзүүлэх, сургалт, зөвлөгөө | | + | + | + | + |
| 5. | Цөсний өвчтэй хүнд сувилахуйн тусламж үзүүлэх, сургалт, зөвлөгөө | | + | + | + | + |
| 6. | Саа, саажилттай хүнд сувилахуйн тусламж үзүүлэх, | | + | + | + | + |
| 7. | Чихрийн шижинтэй хүнд үзүүлэх сувилахуйн тусламж (цусан дахь сахар үзэх, хөлөө шалгах, хөлийн хумс авах, гутал сонгох, инсулиний зөвлөмж, цусны даралтаа хянах, хоолны дэглэм, эмийн хэрэглээний талаар зөвлөмж) | | + | + | + | + |

| № | Тусламж,үйлчилгээний нэр | Эх сурвалж, анхаарах зүйлс | Хэвтүүлэн эмчлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Өдрөөр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Сувилахуйн зөвлөгөө өгөх тусламж, үйлчилгээ |
|---|---|---|---|---|---|---|
| 13. ХҮНД, ХЭВТРИЙН ӨВЧТӨНД ҮЗҮҮЛЭХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ | | | | | | |
| 1. | Үйлчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх, сувилахуйн мэргэжлийн цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх | Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагуудаар батлагдсан баримт бичиг,<br><br>ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана. | + | + | + | + |
| 2. | Гэр бүлийн гишүүдийг хэвтрийн хүнд өвчтөнийг асрахад сургах | | + | + | + | + |
| 3. | Хэвтрийн өвчтөний байрлал өөрчлөх, хөдөлгөх, холголт цооролтоос урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээ үзүүлэх, сургалт, зөвлөгөө | | + | + | + | + |
| 4. | Өвчтөнийг орноос буулгах, суулгах, түшлэгтэй сандалд суулгах, бие засах газрын суултуур, хөтөвчинд суулгах, салхилуулах | | + | + | | |
| 5. | Унаж бэртэхээс сэргийлэх, үйлчлүүлэгчийг салхилуулах, үйлчлүүлэгчтэй ярилцах, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх | | + | + | | |
| 6. | Хэвтрийн өвчтөний бүтэн биеийн угаалга хийх | | + | + | | |
| 7. | Хэсэгчилсэн угаалга (толгойн үс, шүд, ам, нүүр, бэлэг эрхтэн) | | + | + | | |
| 8. | Эмэгтэйчүүдийн өвчний үед үтрээг угаах, цацлага, эмийн бодис хэрэглэх | | + | + | + | |
| 14. СЭРГЭЭН ЗАСАХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ | | | | | | |
| 1. | Бүх биеийн иллэг, бариа, толгой, хүзүүний иллэг, бариа | Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг, | + | + | + | |
| 2. | Биеийн ерөнхий байдал сайжруулах, бүх төрлийн эмийн бус тусламж, үйлчилгээ, | | + | + | + | |

| № | Тусламж,үйлчилгээний нэр | Эх сурвалж, анхаарах зүйлс | Хэвтүүлэн эмчлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Өдрөөр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Сувилахуйн зөвлөгөө өгөх тусламж, үйлчилгээ |
|---|---|---|---|---|---|---|
| | нөхөн сэргээх дасгал хөдөлгөөн, хоол эмчилгээ | ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана. | | | | |
| 3. | Сэргээн засах сувилгаа (Хийн дасгал, биеийн тамир эмчилгээ, бариа засал, хөдөлгөөн засал гэх мэт) | | + | + | + | |
| 4. | Саажилттай өвчтөнд дасгал хөдөлгөөн зааж сургах | | + | + | + | + |
| 5. | Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчид бие даах, өөрийгөө асрах чадварт сургах, дасгал хөдөлгөөн заах, зөвлөгөө өгөх, тэргэнцэр, туслах хэрэгслийг ашиглаж сургах | | + | + | + | + |
| 6. | Осол гэмтлийн дараах архаг байдалтай байгаа үйлчлүүлэгчид бие даах, өөрийгөө асрах чадварт сургах, дасгал хөдөлгөөн заах, зөвлөгөө өгөх, туслах хэрэгслийг ашиглаж сургах | | + | + | + | + |
| 7. | Зөгийн балтай татлага | | + | + | + | |
| 8. | Биеийн хөшингө гаргах, татлага хийх, хөдөлгөөн засал | | + | + | + | |
| 9. | Эмчилгээний биеийн тамирын дасгал, хөдөлгөөн заах | | + | + | + | + |
| 10. | Биед хэсэгчилсэн болон бүх биенд иллэг хийх | | + | + | + | |
| 11. | Тосон болон сүүн бариа хийх | | + | + | + | |
| 12. | Өвчний хурц үеийн дараах үлдэц, цаашид эмчилгээ сувилгаа, хяналтыг гэрийн нөхцөлд урт хугацаагаар үргэлжлүүлэх эмчийн заалттай үйлчлүүлэгчид үзүүлэх сувилахуйн тусламж, сургалт, зөвлөгөө | | + | + | + | + |

| № | Тусламж,үйлчилгээний нэр | Эх сурвалж, анхаарах зүйлс | Хэвтүүлэн эмчлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Өдрөөр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Сувилахуйн зөвлөгөө өгөх тусламж, үйлчилгээ |
|---|---|---|---|---|---|---|
| 13. | Мэс заслын дараах нөхөн сэргээх асаргаа, сувилгаа, сурглт, зөвлөгөө | | + | + | + | + |
| 14. | Өвчтөнийг шинжилгээнд бэлтгэх | | + | + | | |
| 15. | Цус, шээсний ерөнхий шинжилгээ авах | | + | + | | |
| 16. | Цөс угаах | | + | + | + | |
| 17. | Эм уулгах | | + | + | + | + |
| 18. | Шулуун гэдсээр эм хэрэглэх | | + | + | | |
| 19. | Арьс салстад эмийн бодис хэрэглэх (шавших, угаах, түрхэх) | | + | + | + | |
| 20. | Шээс задгайрсан үед авах сувилахуйн тусламж, сургалт, зөвлөгөө | | + | + | + | + |
| 21. | Давсганд шээлгүүр тавих | | + | + | + | |
| 22. | Өтгөн хаталттай өвчтөний сувилахуйн тусламж, үйлчилгээ, сургалт, зөвлөгөө | | + | + | + | + |
| 23. | Өтгөн задгайрсан үед үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ, сургалт, зөвлөгөө | | + | + | + | + |
| 24. | Хооллолтын бэрхшээлтэй өвчтөний сувилахуйн тусламж, үйлчилгээ, сургалт, зөвлөгөө | | + | + | + | + |
| | 15. ӨДӨР ТУТМЫН АСАРГАА, СУВИЛГАА | | | | | |
| 1. | Орны цагаан хэрэглэл солих, ор цэвэрлэх | Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг, | + | + | | |
| 2. | Үс самнах, усанд оруулах | | + | + | | |
| 3. | Хувцас солих (дотуур, гадуур) хувцаслах | | + | + | | |
| 4. | Нэг удаагийн ариун цэврийн хэрэглэл солих (памперс, тампон) | | + | + | | |
| 5. | Нэг удаагийн ариун цэврийн хэрэглэл тавих, солих, арчилгаа (колопласт, иелопласт, шээлгүүр) | ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмжүүдийг | + | + | | |

| № | Тусламж,үйлчилгээний нэр | Эх сурвалж, анхаарах зүйлс | Хэвтүүлэн эмчлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Өдрөөр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Сувилахуйн зөвлөгөө өгөх тусламж, үйлчилгээ |
|---|---|---|---|---|---|---|
| 6. | Толгойг угаах | ашиглана. | + | + | | |
| 7. | Амны хөндий арчлах, сургалт, зөвлөгөө | | + | + | + | + |
| 8. | Цагаан хэрэгсэл солих | | + | + | | |
| 9. | Хэвтрийн өвчтөнийг хооллох | | + | + | | |
| | **16. ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ** | | | | | |
| 1. | Зөв хооллолт, хөдөлгөөн, артерийн даралт, болон цусан дахь сахарын хяналт, сургалт, зөвлөгөө | Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг,<br><br>ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн зөвлөмж ашиглана. | + | + | + | + |
| 2. | Үйлчлүүлэгчийн ар гэрийнхэнд сургалт явуулах (Эм тогтмол уух, хэвтрийн үйлчлүүлэгч, харвалтын дараах нөхөн сэргээх, бие даах чадварыг сайжруулах, хооллолт болон шингэний баланс тооцох) | | + | + | + | + |
| 3. | Сэтгэл засал, зөвлөгөө өгөх сувилахуй | | + | + | + | + |
| 4. | Эрүүл, аюулгүй амьдрах орчин, нөхцөл бүрдүүлэх, эрүүл амьдралын хэв, маяг бүрдүүлэх зөвлөгөө өгөх | | + | + | + | + |
| 5. | Эрүүл мэндийн боловсрол олгох бусад сургалт, сурталчилгаа | | + | + | + | + |
| | **17. ГЭМТЭЛ, БЭРТЛИЙН ДАРААХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ** | | | | | |
| 1. | Төрөл бүрийн гэмтлийн мөчдийн боолт | Эрүүл мэндийн сайдын тушаалаар болон эрх бүхий байгууллагаар батлагдсан баримт бичиг, ДЭМБ болон олон улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн | + | + | + | |
| 2. | Төрөл бүрийн мэс заслын шархны боолт солих, оёдол авах | | + | + | + | |
| 3. | Гэмтэл, бэртэлт, цус алдалтын үед авах анхны тусламж | | + | + | + | |
| 4. | Цэр ховхлох, утлага хийх, механик аргаар | | + | + | + | |

| № | Тусламж,үйлчилгээний нэр | Эх сурвалж, анхаарах зүйлс | Хэвтүүлэн эмчлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Өдрөөр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Сувилахуйн зөвлөгөө өгөх тусламж, үйлчилгээ |
|---|---|---|---|---|---|---|
| | гаргах | зөвлөмж ашиглана. | | | | |
| 5. | Гэдэс дүүрэлтийг намдаах даралтат иллэг | | + | + | + | |
| 6. | Өвчтөн амирлах үеийн бие засал, гэр бүлийн уй гашууг хуваалцах, нимгэлэх, зөвлөгөө өгөх | | + | + | | |
| | 18. ЭМЧИЙН ЗААЛТААР ХИЙХ СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ | | | | | |
| 1. | Арьсан дор тарилга хийх | MNS 4621:2008 | + | + | + | |
| 2. | Булчинд тарилга хийх | | + | + | + | |
| 3. | Судсанд тарилга хийх | | + | + | + | |
| 4. | Дуслаар шингэн сэлбэх | | + | + | + | |
| 5. | Арьсан дотор тарилга хийх | | + | + | + | |
| 6. | Хураагуур судас хатгаж, шинжилгээнд цус авах | | + | + | + | |
| 7. | Үйлчлүүлэгчид гич наах | | + | + | + | |
| 8. | Үйлчлүүлэгчид бумба тавих | | + | + | + | |
| 9. | Үйлчлүүлэгчид цэвэрлэх бургуй тавих | | + | + | + | |
| 10. | Үйлчлүүлэгчийн амьсгал тоолох | | + | + | + | |
| 11. | Үйлчлүүлэгчийн халуун хэмжих | | + | + | + | |
| 12. | Үйлчлүүлэгчийн ходоод угаах | | + | + | + | |
| 13. | Үйлчлүүлэгчид шээлгүүр тавих | | + | + | + | |
| 14. | Ходоод гэдэс угаах, эмчилгээний бургуй тавих | | + | + | + | |
| 15. | Гэдэсний хий гаргах гуурс тавих | | + | + | + | |
| 16. | Давсаг угаах, шээс авах (эмчийн заалтаар) | Эмчийн хяналт, зөвлөмжийн дор | + | + | + | |
| 17. | Ходоод хаймсуурдах, угаах (эмчийн хяналт дор) | | + | + | + | |
| 18. | Цесний хүүдий хаймсуурдах, угаах (эмчийн хяналт дор) | | + | + | + | |

| № | Тусламж,үйлчилгээний нэр | Эх сурвалж, анхаарах зүйлс | Хэвтүүлэн эмчлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Өдрөөр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээ | Сувилахуйн зөвлөгөө өгөх тусламж, үйлчилгээ |
|---|---|---|---|---|---|---|
| 19. | Эмчийн зөвшөөрөл бүхий бусад эмийн эмчилгээ | | + | + | + | |
| 20. | Эмчийн заалтаар үзүүлэх бусад тусламж, үйлчилгээ, сургалт, зөвлөгөө | | + | + | + | + |

## Хоёр. Төвийн халдварын сэргийлэлт, хяналтад баримтлах гол эрх зүйн заалтууд.

| № | Баримтлах стандарт | Эх сурвалж |
|---|---|---|
| 1 | "Эрүүл мэндийн байгууллагуудад халдваргүйжүүлэх бодисын жилийн хэрэгцээг тооцох аргачлал" | Эрүүл мэндийн сайдын 2012 оны 192 дугаар тушаал |
| 2 | "Журам батлах тухай"- халдварын сэргийлэлт, хяналт | Эрүүл мэндийн сайдын 2014 оны 186 дугаар тушаал |
| 3 | "Заавар батлах тухай"- халдварын сэргийлэлт, хяналт | Эрүүл мэндийн сайдын 2014 оны 187 дугаар тушаал |
| 4 | Гар угаах | MNS 4621:2008 |
| 5 | Бээлий өмсөх | |
| 6 | Гардан үйлдэл хийхэд баримтлах ерөнхий зарчим | |
| 7 | Тарилга хийхэд баримтлах аюулгүй ажиллагаа | |
| 8 | Туншлаас эмийн бодис соруулж тарих арга техник | |
| 9 | Флаконтой эмийг найруулж тариа хийх | |

## ГУРАВ. Мэргэжлийн сувилахуйн багийн гишүүдийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны үлгэрчилсэн жишиг.

### 3.1 Магистрын боловсролын зэрэгтэй сувилагчийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны үлгэрчилсэн жишиг:

- Төвийн удирдлага,
- Тасаг нэгжийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх,
- Сувилахуйн тусламж, үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт,
- Сувилахуйн тусламж, үйлчилгээтэй холбоотой үүрэг даалгавар өгөх, биелэлтийг хянах, ажил үүргийг дүгнэх,
- Сувилахуйн тусламж, үйлчилгээний менежментийн төлөвлөгөө зохиох,
- Сувилгааны үйл ажиллагааны 5 шатлал (Үйлчлүүлэгчийн биеийн байдалд бие даан үнэлгээ өгөх, үзлэг хийх, сувилахуйн онош тавих, сувилах төлөвлөгөө зохиох, хэрэгжүүлэх, дүгнэх)-ыг бие даан гүйцэтгэх,
- Сувилахуйн тусламж, үйлчилгээний гардан үйлдлийг бие даан гүйцэтгэх,
- Сувилахуйн үйл ажиллагааны 5 шатлал хэрэгжүүлэгч сувилагч болон багийн ажлыг удирдан чиглүүлэх,
- Үйлчлүүлэгчид үүссэн, шийдвэрлэхэд хүндрэлтэй асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргах,
- Үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөх, сургах, дадлагажуулах, гаргах, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх,
- Сувилагчид мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургах, дадлагажуулах,

- Үйлчлүүлэгч, тэдний гэр бүлийн гишүүдтэй харилцах, үйлчлүүлэгчийн эрүүл мэндтэй холбоотой асуудлаар мэдээлэл солилцох,
- Сувилахуйн эрдэм, шинжилгээ, судалгааны ажлыг гүйцэтгэх, удирдах, чиглүүлэх, зөвлөх, зохион байгуулах,
- Хөдөлгөөн засалч, хэл засалч, нөхөн сэргээх сувилагч, хоол зүйч, нийгмийн ажилтан, сайн дурынхан, сувилагчийн туслах, зэрэг олон мэргэжлийн багийн хамтын ажиллагааг хангаж ажиллах,
- Байгууллагын дотоод журам, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм, хэмжээг сахин, мэргэжлийн алдаа, зөрчил гаргасан тохиолдолд хууль, журмын дагуу зохих хариуцлага хүлээх, хүлээлгэх,

3.2 Бакалаврын боловсролын зэрэгтэй сувилагчийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны үлгэрчилсэн жишиг:

- Магистр болон дээш цолтой сувилагчийн мэргэжлийн удирдлага дор ажиллах,
- Тасаг нэгжийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх,
- Сувилахуйн тусламж, үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт,
- Сувилахуйн тусламж, үйлчилгээтэй холбоотой үүрэг даалгавар өгөх, биелэлтийг хянах, ажил үүргийг дүгнэх,
- Сувилахуйн тусламж, үйлчилгээний менежментийн төлөвлөгөө зохиох,
- Сувилгааны үйл ажиллагааны 5 шатлал (Үйлчлүүлэгчийн биеийн байдалд бие даан үнэлгээ өгөх, үзлэг хийх, сувилахуйн онош тавих, сувилах төлөвлөгөө зохиох, хэрэгжүүлэх, дүгнэх)-ыг бие даан гүйцэтгэх,
- Сувилахуйн тусламж, үйлчилгээний гардан үйлдлийг бие даан гүйцэтгэх,
- Сувилахуйн үйл ажиллагааны 5 шатлал хэрэгжүүлэгч сувилагч болон багийн ажлыг удирдан чиглүүлэх,
- Үйлчлүүлэгчид үүссэн, шийдвэрлэхэд хүндрэлтэй асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргах, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх,
- Үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөх, сургах, дадлагажуулах
- Сувилагчид мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургах, дадлагажуулах,
- Үйлчлүүлэгч, тэдний гэр бүлийн гишүүдтэй харилцах, үйлчлүүлэгчийн эрүүл мэндтэй холбоотой асуудлаар мэдээлэл солилцох,
- Сувилахуйн эрдэм, шинжилгээ, судалгааны ажлыг гүйцэтгэх, удирдах, чиглүүлэх, зөвлөх, сургалт зохион байгуулах,
- Дипломын сувилагч болон сувилагчийн туслахад мэргэжлээрээ зөвлөн, туслах үүрэг гүйцэтгэх,
- Дипломын сувилагчийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавих,
- Хөдөлгөөн засалч, хэл засалч, нөхөн сэргээх сувилагч, хоол зүйч, нийгмийн ажилтан, сайн дурынхан, сувилагчийн туслах, зэрэг олон мэргэжлийн багтай хамтарч ажиллах,
- Байгууллагын дотоод журам, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм, хэмжээг сахин, мэргэжлийн алдаа, зөрчил гаргасан тохиолдолд хууль, журмын дагуу зохих хариуцлага хүлээх, хүлээлгэх,

### 3.3 Дипломын боловсролын зэрэгтэй сувилагчийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны үлгэрчилсэн жишиг:

- Магистр, бакалавар сувилагчийн мэргэжлийн удирдлага дор ажиллах,
- Сувилгааны үйл ажиллагааны 5 шатлал (Үйлчлүүлэгчийн биеийн байдалд бие даан үнэлгээ өгөх, үзлэг хийх, сувилахуйн онош тавих, сувилах төлөвлөгөө зохиох, хэрэгжүүлэх, дүгнэх)-ыг бие даан болон магистр, бакалавр сувилагчтай хамтран гүйцэтгэх,
- Сувилахуйн тусламж, үйлчилгээний гардан үйлдлийг бие даан болон хамтран, багаар гүйцэтгэх,
- Сувилахуйн үйл ажиллагааны 5 шатлал хэрэгжүүлж, багийн бүрэлдэхүүнд ажиллах,
- Үйлчлүүлэгчид үүссэн, шийдвэрлэхэд хүндрэлтэй асуудлыг хамтарч шийдвэрлэх, шийдвэрлүүлэх,
- Үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөх, сургах, дадлагажуулах, гаргах, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх,
- Ижил мэргэжилтний үнэлгээнд оролцох,
- Үйлчлүүлэгч, тэдний гэр бүлийн гишүүдтэй харилцах, үйлчлүүлэгчийн эрүүл мэндтэй холбоотой асуудлаар мэдээлэл солилцох,
- Сувилахуйн эрдэм, шинжилгээ, судалгааны ажлыг гүйцэтгэх,
- Хөдөлгөөн засалч, хэл засалч, нөхөн сэргээх сувилагч, хоол зүйч, нийгмийн ажилтан, сайн дурынхан, сувилагчийн туслах, зэрэг олон мэргэжлийн багтай хамтарч ажиллах,
- Туслах сувилагчийн үйл ажиллагаанд мэргэжлээрээ зөвлөн, туслах үүрэг гүйцэтгэх,
- Туслах сувилагчийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавих,
- Хөдөлгөөн засалч, хэл засалч, нөхөн сэргээх сувилагч, хоол зүйч, нийгмийн ажилтан, сайн дурынхан, сувилагчийн туслах, зэрэг олон мэргэжлийн багтай хамтарч ажиллах,
- Байгууллагын дотоод журам, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм, хэмжээг сахин, мэргэжлийн алдаа, зөрчил гаргасан тохиолдолд хууль, журмын дагуу зохих хариуцлага хүлээх,

### 3.4 Сувилагчийн туслахын гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны үлгэрчилсэн жишиг:

- Мэргэжлийн сувилагчийн удирдлага дор ажиллах,
- Сувилахуйн мэргэжилтнүүдийн багтай хамтарч ажиллах,
- Мэргэжлийн сувилахуйн тусламж, үйлчилгээнээс бусад туслах үйлчилгээг хэрэгжүүлэх,
- Үйлчлүүлэгчийн ор цэвэрлэх, засах,
- Хөтөвч тавих, цэвэрлэх,
- Үс угаах, самнах,
- Үйлчлүүлэгчийг шүршүүрт оруулах, ваннанд оруулах, хэсэгчилсэн угаалга хийх,

- Үйлчлүүлэгчийн шүд угаах, ам цэвэрлэх,
- Бие засахад нь туслана
- Живх солих,
- Босч суух, явахад нь туслана
- Хөдөлгөөн хийхэд зориулагдсан туслах хэрэгсэл дээр зөвшөөрөгдсөн дасгал, хөдөлгөөнийг сувилагчийн хамт хийлгэх,
- Алхах болон тэргэнцрээр явахад нь туслах,
- Сэтгэл санаагаар нь дэмжих, ярилцах,
- Хооллох, эрсдэлт хүчин зүйлийг багасгах,
- Өрөөний гэрэлтүүлэг, орчны тав тухтай байдлыг хангах,
- Цэвэрлэгээ, ариутгал хийх,

Эрүүл мэндийн сайдын
2017 оны ... сарын ... -ны өдрийн
... дугаар тушаалын 3 дугаар хавсралт

# ТӨВД ИЛГЭЭХ ӨВЧИН, ЭМГЭГИЙН ЖАГСААЛТ

## Нэг. Төвд үйлчлүүлэгчийг хүлээн авах шалгуур.

1.1 Бусдын туслалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй, байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай үйлчлүүлэгчийг энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтад заасан сувилахуйн тусламж, үйлчилгээнд хамруулахаар өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, эмнэлгээс ирүүлнэ.

1.2 Үйлчлүүлэгчийн харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, эмнэлэг нь үйлчлүүлэгчийг сувилахуйн төвд шилжүүлэх асуудлыг олон мэргэжлийн багийн эмч, өвчтөн, түүний гэр бүлийнхэнтэй зөвшилцөн шийдвэрлэж, илгээх бичиг /13а/ маягтаар илгээнэ.

1.3 Сувилахуйн цогц тусламж, үйлчилгээ шаардлагатай үйлчлүүлэгчид эмчийн заалтаар үзүүлэх тусламж, үйлчилгээнд цаашид үргэлжлүүлэн хийх шаардлагатай эмчилгээний заалт, үргэлжлэх хугацаа, давтамж, тун хэмжээг нарийвчлан зааж үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн дэвтэрт нь буюу, шилжүүлэх бичигт хавсаргасан байна.

1.4 Аль нэг эрхтэн, системийн өвчлөлийн архаг шатанд орсон, урт хугацаанд сэргэх явцтай, цаашид бусдын дэмжлэг, урт хугацаанд асаргаа, сувилгаа зайлшгүй шаардлагатай үйлчлүүлэгчийг төвийн тусламжинд хамруулахдаа дараах шалгуур болон бусад холбогдох үндэслэлээр магадлана. Үүнд:

1.4.1 Үйлчлүүлэгчийн өвчин эмгэг нь халдварт бус өвчний архаг үе,

1.4.2 Үйлчлүүлэгчийн өвчин эмгэг нь амь насанд нь шууд аюул учруулахааргүй буюу өвчний ээнэгшлийн үе,

1.4.3 Үйлчлүүлэгч ухаангүй, хүнд, оврогын байдалгүй, буюу өвчний улмаас хүндрэлд орох эрсдэлгүй байх,

1.4.4 Үйлчлүүлэгч төвөөр үйлчлүүлэх тусламж, үйлчилгээний заалтад нийцсэн байх,

1.4.5 Үйлчлүүлэгч, ялангуяа хүүхэд, нярай болон хөгжлийн бэрхшээлтэй, өөрөө шийдвэр гаргах чадваргүй үйлчлүүлэгчийн гэр бүлийн голлох гишүүний нэмэлт зөвшөөрөлтэй байх,

1.5 Эдгээр болон бусад шалгуурыг харгалзахдаа өвчний хурц, хурцадмал үед илгээхгүй байх, хоёр, гуравдугаар шатлалын эмнэлгийн байгууллагаар зайлшгүй эмчлүүлэх заалттай үйлчлүүлэгчийг илгээхгүй байх нь гол үндэслэл болгоно.

1.6 Үйлчлүүлэгчийг илгээсэн байгууллага нь шалгуурыг буруу тогтоосноос үүссэн аливаа хүндрэл, хариуцлагыг хүлээнэ.

1.7 Үйлчлүүлэгчийг илгээсэн байгууллагын эмч нь төвд ирж, илгээсэн үйлчлүүлэгчийнхээ эрүүл мэндийн байдалд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж болно.

**Хоёр Эсрэг заалт:**

- Өвчний хурц, хурцадмал үе,
- Сэтгэцийн өвчнүүд,
- Халдварт өвчнүүд,

**Гурав. Төвд үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээний баталгаажилт**

3.1 Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээнээс бусад үйлчилгээний төрөл төрөлөөс /өдрөөр, хэвтүүлэн, зөвлөгөө өгөх/ үл хамааран үйлчлүүлэгч бүрт сувилахуйн түүх нээж, үзүүлсэн тусламж үйлчилгээгээ баталгаажуулан, үр дүнг тооцож ажиллана.

3.2 Энэхүү жагсаалтад заасан сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлснийг баталгаажуулахдаа Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан сувилгааны түүхийн хамгийн сүүлийн баримт бичгийг ашиглана.

**Дөрөв. Үйлчлүүлэгчийн гэр бүл, асран халамжлагчийн хүлээх үүрэг:**

4.1 Үйлчлүүлэгч болон түүний гэр бүл, асран халамжлагч нь тэдэнтэй эргэх холбоо барих бүх төрлийн мэдээллийг төвд бичгээр үлдээнэ.

4.2 Сувилахуйн хэвтүүлэн эмчлэх үйлчилгээтэй төвд үйлчлүүлэгчийг ирснээс хойш төвийн дотоод журамд заасан хугацаанд тасралтгүй биеэр ирж болон, бусад харилцаа, холбооны хэрэгслээр дамжуулан тасралтгүй холбоотой байх үүргийг хүлээнэ.

4.3 Үйлчлүүлэгчийн биеийн байдалд гарч буй эерэг, сөрөг байдлын талаар мэдээлэл авч, цаашид төвөөр үйлчлүүлэхийг зөвшөөрч байгаа, эс зөвшөөрч байгаа тухайг төвийн дотоод журамд заасан хугацаанд багтаан тогтмол бичгээр баталгаажуулж сунгаж, цуцалж байна.

4.4 Үйлчлүүлэгчийн өвөрмөц нөхцөлд тохирсон орчин, нөхцөл бүрдүүлүүлэх талаар саналаа хэлэх, шаардлагатай нэмэлт материал, тоног төхөөрөмжийг хангуулах болон хувиараа хангах талаар саналаа илэрхийлж болно.

4.5 Үйлчлүүлэгчийн гэр бүл, асран хамгаалагч нь өвчин эмгэгийнх нь эмгэг жам, өвөрмөц, нөхцөл, цаашид хийх сувилахуйн тусламж, үйлчилгээний талаар мэдээллийг авах эрхтэй.

**Тав. Илгээх өвчин эмгэгийн жагсаалт.**

5.1 Төвийн үйл ажиллагааны ерөнхий чиг үүрэг нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, эмнэлгээс илгээсэн, урт хугацаанд эмчилгээ, асаргаа,

сувилгаа, нөхөн сэргээлт шаардлагатай, дараах өвчин эмгэгүүдийн намжмал болон архаг шатанд байгаа үед сувилахуйн тусламж, үйлчилгээг үзүүлнэ: Үүнд:

5.1.1 Урт хугацаанд асаргаа, сувилгаа шаардагдах, архаг өвчтэй хүүхэд, насанд хүрэгч,настны өвчин, эмгэг,

5.1.2 Бүх төрлийн мэс заслын дараа, урт хугацаанд хяналтад байж, нөхөн сэргээлт, байнгын асаргаа, сувилгаа шаардагдах өвчин, эмгэг,

5.1.3 Осол, гэмтэл, бэртэлийн дараах нөхөн сэргээх өвчин, эмгэг,

5.1.4 Байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй, хүүхэд,насанд хүрэгч, настны өвчин, эмгэг,

5.1.5 Цус харвалтын дараах архаг эмгэг, өөрчлөлтийн үеийн сувилахуйн болон нөхөн сэргээлт шаардлагатай үе,

5.1.6 Өөртөө үйлчлэх чадвар алдагдсан, заавал бусдын дэмжлэгтэйгээр өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулах шаардлагатай өвчний архаг үе,

5.1.7 Өдрөөр хийгдэх эмийн эмчилгээ, сувилгаа,

5.1.8 Сэргээн засах эмчилгээ, сувилгаа шаардлагатай өвчний үе /Хийн дасгал, биеийн тамир эмчилгээ, зүү эмчилгээ, бариа засал, иллэг гэх мэт/

5.1.9 Байнгын хяналтад байх шаардлагатай эх, хүүхдийн өвчин, эмгэг,

5.1.10 Эрүүл мэндийн боловсрол олгох (Зөв хооллолт, хөдөлгөөн, артерийн даралт, болон цусан дахь сахарыг гэрээр өөрөө хянах гм),

5.1.11 Үйлчлүүлэгчийн ар гэрийнхэнд сургалт явуулах (Эм тогтмол уух, хэвтрийн үйлчлүүлэгч, харвалтын дараах нөхөн сэргээх, бие даах чадварыг сайжруулах, хооллолт болон шингэний баланс тооцох, хэсэгчилсэн болон бүтэн биеийн угаалга..., гм),

5.1.12 Гэрээр сувилахуйн тусламж, үйлчилгээ авах захиалгат үйлчилгээ,

ТӨГСӨВ